



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 19 өдөр


Дугаар 382



Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө худалдах зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 4, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 22,870,600.00 (хорин хоёр сая найман зуун далан мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.
2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Б.Отгончимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
  - 2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
  - 2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;
  - 2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;
  - 2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ  
TYP ORLOH GÜYCETGEGCH   
 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА   
 Б.ГАВАА

0002593

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн  
 хавсралт

**ГОВЬ-СҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР  
 ХУДАЛДАХ АВТОМАШИН**

Д/д	Суудлын автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдээгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин "Соната-6", ГСА 58-87	2006/2007	22,870,600.00	22,870,600.00	-	500,000.00
	<b>Нийт дүн</b>		<b>22,870,600.00</b>	<b>22,870,600.00</b>	<b>-</b>	<b>500,000.00</b>

(хорин хоёр сая  
 найман зуун  
 далан мянга  
 зураган зуун)

(хорин хоёр сая  
 найман зуун  
 далан мянга  
 зураган зуун)

(таван зуун мянган)